

Академич Бямбажавын Рагчаагийн дотор өвчний онош зүй ба элэг судлалын салбарыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр

Д.Долгион^{1,2}, Л.Тулгаа², Н.Бира¹, С.Бадамжав¹, А.Энх-Амар¹

¹АШУУИС, Анагаах ухааны сургууль, ХБЭСТ

²Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит Анагаах ухааны хүүрэлэн

Цахим шуудан: dolgion.ims@mtums.edu.mn, Утас: +976 99659303

Түлхүүр үг:

Анагаахын
шинжлэх ухаан
Вируст гепатит
Түүх
Эрдэм шинжилгээ

Товч утга:

Үндэслэл: Эмнэл зүйн анагаах ухааны хаан хэмээн зүй ёсоор нэрлэгддэг дотрын анагаах ухааныг Монгол Улсад үүсгэн хөгжүүлэхэд МУИС-ийн хүн эмнэлгийн факультетын анхны төгсөгчдийн нэг, анхны дотрын эмч, багш, дотрын эмгэг судлалын анхны аспирант, эрдэмтэн, анхны монгол декан, дотрын тэнхимийн анхны монгол эрхлэгч, анхны профессор, Монгол улсын хүний гавьяат эмч, Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн анхны сурвалжлагч гишүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, академич Б.Рагчаа жинтэй хувь нэмэр оруулсан билээ. **Зорилго:** Академич Бямбажавын Рагчаагийн бүтээлийн судалгааг хийснээр Дотор өвчний онош зүй ба болон элэг судлалын салбарыг үндэслэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг судлах, нийтэд түгээх. **Арга, аргачлал:** Судалгааг нэрт эрдэмтэн, академич Б.Рагчаагийн хэвлэн нийтлүүлсэн ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, архивын материал болон Б.Рагчаа багшийн тухай дурдсан ном, сонин, үе үеийн шавь нарын дурсамж яриа, бичвэрүүдийг түүвэрлэн, баримтын судалгааны аргаар дүн шинжилгээ хийлээ. **Үр дүн:** Академич Б.Рагчаа нь багшлах хугацаандаа 4000 орчим эмч мэргэжилтэн төгсгөн гаргаж, нийт 156 бүтээл туурвисан байна. Мөн өөрийн олон жилийн мэдлэг, чадвар, туршлага дээр үндэслэн, “Боткины өвчний эмнэл зүй” (1969), “Дотрын өвчний хам шинж” (1972) сурах бичгүүдийг бичсэнээрээ “Анхны Монгол сурах бичиг бичсэн” эрдэмтэн багш болж алдаршсан. Профессор Б.Рагчаа элэгний өвчний талаар бичсэн бүтээлүүдээ нэгтгэж дүгнэн 1977 онд “Боткины өвчний эмнэл зүй” гэдэг нэг сэдэвт зохиол бичиж анагаахын шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг хамгаалжээ. **Дүгнэлт:** 1. Бямбажавын Рагчаа нь 1953 онд “Дотор өвчний онош зүйн” тэнхимийн анхны монгол эрхлэгчээр томилогдсоноос хойш 52 жил багшилж, 42 жил дотрын зөвлөхөөр ажилласан ба дотрын онош зүйн шинжлэх ухаанд чухал хувь нэмэр оруулсан нэрт эрдэмтэн байжээ. 2. Академич Б.Рагчаа нь вируст гепатитын судалгааг удирдан явуулж, “Боткины өвчний эмнэл зүй” нэг сэдэвт зохиол бичиж хэвлүүлэн АШУ-ны докторын (1977) зэрэг хамгаалсан элэгний анхны мэргэжлийн эрдэмтэн судлаач багш юм.

Үндэслэл: Түүх бол өнгөрсөн цаг хугацаан дах хүмүүсийн хийж бүтээсэн үйл хэргийн талаарх мэдлэг ухаан юм¹. Түүхэн үе бүрд ажиллаж байсан эрдэмтэн судлаачид маань Монгол Улсынхаа хөгжил дэвшилд баларшгүй ул мөрөө үлдээж, үе үеийнхний залгамж холбооны алтан хэлхээг бүтээжээ². Эрүүл мэндийн

салбарын түүхийг тодруулан судлах нь цаашдын хөгжлийн чиглэл, хандлагаа оновчтой тогтоох чухал практик ач холбогдолтой. Монгол улсын их сургууль (МУИС) 1942 оны 10 сарын 5-нд байгуулагдаж түүний харьяанд хүн эмнэлгийн факультет 34 оюутантай (24 монгол, 10 орос), 7 тэнхимтэйгээр хичээлээ эхэлсэн

ба үүнээс 13 эмч 1947 онд анхны эмч болж бэлтгэгдэн төгсжээ.³ Энэ үеэс манай улсад орчин үеийн анагаах ухааны үндэс суурь тавигдаж, дотрын онош зүй, элэг судлалын шинжлэх ухаан хөгжиж эхэлсэн. XX зуунд Монголын анагаах ухааны салбаруудын дотроос эмнэл зүйн анагаах ухаан илүү хөгжсөн түүхтэй.⁴ Эмнэл зүйн анагаах ухааны хаан хэмээн зүй ёсоор нэрлэгддэг дотрын анагаах ухааныг Монгол Улсад үүсгэн хөгжүүлэхэд МУИС-ийн хүн эмнэлгийн факультетын анхны төгсөгчдийн нэг, анхны дотрын эмч, багш, дотрын эмгэг судлалын анхны аспирант, эрдэмтэн, анхны монгол декан, дотрын тэнхимийн анхны монгол эрхлэгч, анхны профессор, Монгол улсын хүний гавьяат эмч, Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн анхны сурвалжлагч гишүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, академич Б.Рагчаа жинтэй хувь нэмэр оруулсан билээ. Бямбажавын Рагчаа нь эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэх их үйлсэд 52 жил багшилж олон мянган шавь нарыг бэлтгэж, Улсын клиникийн төв эмнэлэгт (УКТЭ)-т 42 жил зөвлөхөөр ажиллаж⁵ байсан нь АУИС-ийн эмнэл зүйн сургалтын үндэсний бааз, улсын клиникийн төв эмнэлгийн өнөөгийн хүрсэн хөгжлийн түвшин нь Бямбажавын Рагчаагийн бүтээлч үйл ажиллагаатай холбоотой төдийгүй одоогийн гол гол салбаруудыг өөрийн шавь нарын хамт үүсгэн байгуулсан билээ. Иймд нэрт эрдэмтний бүтээлийг баримтжуулж, алдар гавьяа, анагаахын шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг нь тодруулан, түгээн дэлгэрүүлэх шаардлагатай байна.

Зорилго: Академич Бямбажавын Рагчаагийн бүтээлийн судалгааг хийснээр Дотор өвчний онош зүй ба элэг судлалын салбар үндэслэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг судлах, нийтэд түгээх зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Зорилт:

1. Академич Бямбажавын Рагчаагийн Дотрын онош зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, ач холбогдлыг тодорхойлох
2. Бямбажавын Рагчаагийн “Элэг судлалын” чиглэлээр туурвисан бүтээлийг судлаж элэгний анхны мэргэжлийн эрдэмтэн судлаач, профессор багш болохыг тодруулах

Арга, аргачлал: Судалгааг нэрт эрдэмтэн, академич Б.Рагчаагийн хэвлэн нийтлүүлсэн ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, архивын материал болон Б.Рагчаа багшийн тухай дурдсан ном, сонин, үе үеийн шавь нарын дурсамж яриа, бичвэрүүдийг түүвэрлэн, баримтын судалгааны аргаар дүн шинжилгээ хийлээ.

Үр дүн:

1. Академич Бямбажавын Рагчаагийн Дотрын онош зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, ач холбогдлыг тодорхойлох: МУИС-ийн захирлын 1944 оны 8 сарын 29-ний өдрийн 36 тоот тушаалаар А.А.Дубинскийг Дотрын өвчнийг шинжлэн судлах тэнхимийн эрхлэгчээр томилсноор Дотрын тэнхимийн суурь тавигдсан түүхтэй.⁶ Б.Рагчаа 1947 онд дотрын тэнхимийн анхны аспирант болж, 1953 онд дотор өвчнийг шинжлэн судлах тэнхимийн эрхлэгчээр анх удаа монгол эрдэмтэн Б.Рагчаа томилогджээ. Академич Б.Рагчаа нь багшлах хугацаандаа 4000 орчим эмч мэргэжилтэн төгсгөн гаргаж, дотрын бүх эмч нарын мэргэжил олгох дээшлүүлэх сургалтад оролцож, 15 хүний эрдмийн ажлыг удирдан зэрэг хамгаалуулж, 22 хүний эрдмийн ажлын албан ёсны шүүмжлэгч хийж, 20 гаруй эмчийг дагалдуулан нарийн мэргэжил эзэмшүүлж, 200 гаруй эмчийн мэргэжлийг дээшлүүлж, эрдэм шинжилгээний өгүүлэл 65, сурах бичиг, гарын авлага 6, нэг сэдэвт зохиол 2, редакторлан хянасан ном 6, нийтэд зориулсан өгүүлэл 22, эрдэм шинжилгээний илтгэл 52, гадаад дотоодын их бага хурлуудад 12 илтгэл тавьж үг хэлж байсан зэрэг нийт 156 бүтээл туурвисан байна^{7,8}. Мөн багшийн ажлын зэрэгцээ, УКТЭ-т 50 шахам зөвлөхөөр ажиллахдаа дотрын тасгуудын суурийг тавихад гар бие оролцон зөвлөхөөр ажиллаж, Улаанбаатар хотын эмнэлгүүдэд нийтдээ 9700 гаруй хүн үзэж, 700 гаруй задлан шинжилгээ хийж, хөдөөгийн 19 аймаг, хотод 46 удаа явж 1200 өвчтөнд оношилгоо, эмчилгээний зөвлөгөө өгсөн байдаг⁹. Рагчаа багш олон өвчнийг Монголд анх удаа оношилж судалж эмнэлгүүдийн архив, ном, сэтгүүлд нийтлүүлсэн нэрт эрдэмтэн хүн юм. Аливаа нэг өвчнийг анх ажиглан, эрдэм судалгааны эргэлтэд оруулан бичсэн хүний нэрээр тухайн өвчнийг нэрлэх явдал анагаах ухаанд элбэг агаад шинжлэх ухааны аливаа салбарт судалгаа, шинжилгээнийх нь үр дүн, хэрэглэгдэхүүнийг тухайн эрдэмтний нэр алдраар мөнхөлдөг нь тогтсон жишиг. Хэрэв манайд ийм зуршлыг мөрддөгсөн бол түүний нэр судалгааны ном, сурах бичгүүдэд нэн олон дурсагдан бичигдэх байсан. Тухайлбал, элэгний бодисын солилцооны эмгэгүүдээс Порфири өвчин (1976), Гемохроматоз, Жильбертийн хамшинж зэрэг өвчнийг Монголд анх удаа оношлон эмчилж байсан¹⁰.

Дотрын тэнхимийн багш нар Академич Б.Рагчаагийн зөвлөгөө, удирдлага дор хийж байсан эрдэм шинжилгээний ажлууд практикт нэвтэрсэн төдийгүй Монголын дотрын шинжлэх ухаанд түүхэн үйл явдлууд болсон ба уян дурангийн шинжилгээ, цөмийн оношилгоо, радиоиммунологийн шинжилгээний арга, хэт авиан шинжилгээ зэрэг өнөөгийн дэлхийн түвшинд хүрсэн эмчилгээ шинжилгээний аргууд нэвтэрсэн нь Монголын анагаах ухааны хөгжилд том дэвшил болсон гэж АУ-ны доктор, профессор Х.Гэлэгжамц тэмдэглэжээ.¹¹ (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Дотрын онош зүйд багажийн шинжилгээний аргууд нэвтэрсэн үе

№	Шинжилгээний аргууд	Багш, судлаач	Он
1	Клиник биохими шинжилгээний аргууд	Б.Рагчаа, Б.Лувсанноров	1947-1959
2	Зүрхний цахилгаан бичлэгийн тухай	Ф.Ф.Борисенко, Б.Рагчаа нар	1953
3	Эрхтэн дурандах арга	Ч.Цэрэннадмид, Ж.Жамъянпавар нар	1969
4	Дотрын сургалтад факультетийн, графологийн арга, слайдын арга	Б.Рагчаа	
5	Хиймэл аппаратаар бөөрний диализ хийх арга	Б.Рагчаа, Х.Тэрбиш, Д.Энхзаяа, Х.Гэлэгжамц нар	1971
6	Радио- изотопын арга	П.Онхуудай, Ш.Жигжидсүрэн, Б.Рагчаа	1972
7	Эрүүл хүнийг мэдрэх анализатор судалсан дүн	Б.Од	1973
8	Клиник биохимийн шинжилгээний аргууд	Б.Лувсанноров	1973
9	Иммунологийн арга	Н.Мөнхтүвшин, Оюун нар	1974
10	Радио-Иммунологийн арга	Ш.Жигжидсүрэн, П.Онхуудай, Оюун нар	1974
11	Мөгөөрсөн хоолойн (астма) багтраа	Ж.Хайрулла	1974
12	Элэгний хорт хавдар, бэтгийг, сцинтиграфийн аргаар оношлох асуудал	БНАГУ, П.Онхуудай	1980
13	Элэгний үрэвслийн шинж тэмдэг, оношилгоо	Б.Дагвадорж	1984
14	Эрүүл хүний захын цусны норматив хэм хэмжээ	Д.Дэжидмаа	1985
15	Элэгний архаг өвчнүүдийг дүрслэл, оношилгооны аргаар оношлох асуудал	ХБНГУ, П.Онхуудай	1991

Бямбажавын Рагчаа нь 1953 онд Москвагийн анагаах ухааны Нэгдүгээр дээд сургууль дээр ЗХУ-ын Хөдөлмөрийн баатар, академич, доктор, профессор Т.М.Тарсеевийн удирдлагаар “Уушгины өнгөрт үрэвслийн тэмбүүгийн үеийн клиник эмчилгээний зарим онцлог” нэг сэдэвт бүтээлээр АУ-ны дэд эрдэмтний зэрэг хамгаалж, дотрын анхны эрдэмтэн болжээ. Мөн өөрийн олон жилийн мэдлэг, чадвар, туршлага дээр үндэслэн “Боткины өвчний эмнэл зүй” (1969), “Дотрын өвчний онош зүй”¹² (1970) сурах бичгүүдийг бичсэнээрээ “Анхны Монгол сурах бичиг бичсэн” эрдэмтэн багш болж алдаршсан.

Академич Б.Рагчаагийн Дотрын онош зүйн чиглэлээр хийсэн эрдэм шинжилгээний ажлуудын нээлт үр дүнгүүдээс¹³:

1. 1947 оноос эхлэн уушгины өнгөрт үрэвслийн эмнэл зүй, эмчилгээг судалсан ба залуу насанд гэнэт тохиолддогийг тогтоож, эмчилгээнд сульфаниламид, пенициллин хэрэглэх аргыг нэвтрүүлжээ.
2. Бөөрний эмгэгийн чиглэлээр Х.Гэлэгжамц нарыг сургаж, бөөрний цочмог ба архаг үрэвслүүд, түүний дутагдлуудыг судлуулан дэд эрдэмтний зэрэг хамгаалуулан, гемодиализ эмчилгээг нэвтрүүлэн олон зуун хүний амь насыг аварсан.
3. Ходоод, дээд гэдэс, нарийн бүдүүн гэдэсний эмгэг судлалын тасгийг байгуулан, клиникт уян дурангийн шинжилгээг нэвтрүүлсэн.
4. Дотрын тэнхимийн багш Ш.Жигжидсүрэн, Ч.Цэрэннадмид нарыг цус судлалын чиглэлээр эрдмийн ажил хийлгэж, дэд эрдэмтний зэрэг хамгаалуулсан.

5. УКТЭ-т дотоод шүүрлийн тасаг, амбулаторийн кабинет байгуулахад оролцож, үндэсний мэргэжилтнүүдийг сургаж, эмчилгээний судалгааны ажлуудыг зохион байгуулж Ж.Сувдаа чихрийн шижин өвчний эмнэл зүй, оношилгоо, эмчилгээг судалж дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байна.

2. Бямбажавын Рагчаагийн “Элэг судлалын” чиглэлээр туурвисан бүтээлийг судалж элэгний анхны мэргэжлийн эрдэмтэн судлаач, профессор багш болохыг тодруулах: Профессор Б.Рагчаа нь элэгний вирусийн шалтгаант цочмог ба архаг гепатитын тархалт, шалтгаан, эмнэл зүй, эмчилгээ, сэргийлэлтийн асуудлаар 1953-1961 он хүртэл өргөн хүрээний судалгааг удирдан явуулжээ. Түүний 1955 онд туурвиж, БНМАУ-ын Хүний их эмч нарын эрдэм шинжилгээний хоёрдугаар их хуралд тавьсан “Элэгний тахал хэлбэртэй халдварт Боткины өвчний халдварлах зам, түүнээс урьдчилан сэргийлэх тухай” хэмээх бүтээл нь манай улсад вируст гепатитыг судлах, тэмцэх асуудлаар дараагийн 20-30 жилд хийх судалгаа, эмнэлгийн үйлчилгээний ажлыг цогцолбор удирдаж хэлбэрээр илэрхийлсэн анхны суурь бүтээл байжээ.¹⁴ Академич П.Няндаваа “Вакцин хэмээх ээлтэй үхэржин” (2009) номондоо вируст гепатитыг Монголд судалсан түүхийг 3 үе шатанд ангилж үзсэн ба Академич Б.Рагчаагийн удирдан явуулж байсан элэгний цочмог үрэвсэлт эмгэгийн тархалт, эмнэл зүйн судалгаанууд нь нэгдүгээр үе шат (1952-1971 он) буюу эпидемиологи, эмнэл зүй дагнасан үетэй дүйж байна¹⁵. Энэ нь Академич Б.Рагчаа нь Монгол улсад вируст гепатитын судалгааны эхийг тавьсныг харуулж байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Монгол улсад вирус гепатитыг судалсан түүх

Үе	Хугацаа	Вирус гепатитыг судалсан чиглэл
I	1952-1971 он	Эпидемиологи, эмнэлзүйн судалгаа дагнасан үе
II	1971-1987 он	Вирус судлалын лабораторийн шинжилгээний арга нэвтэрч эхэлсэн үе
III	1987 оноос хойш	Өвөрмөц сэргийлэлтийн арга нэвтэрч эхэлсэн үе

Вирус гепатитыг үүсгэгчээр нь ялган бүртгэх тогтолцоо манай улсад 1978 оноос албан ёсоор эхэлсэн боловч, академич Б.Рагчаа 1960 онд Х.Чойбалсангийн нэрэмжит, Монгол Улсын Их Сургуулийн “Эрдэм шинжилгээний бичиг”-ийн тавдугаар ботийн дугаар №2-т нийтлүүлсэн “Боткины өвчний зарим нэгэн шинж тэмдэг ба тархалтын байдлыг Улсын төв больницын 1956 оны материалаар гаргаж судалсан нь” өгүүлэлдээ Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлэгсдийн дотор Боткины өвчний эзлэх хувийн жин 1956 онд 1948 оныхоос тав дахин өссөн. 1956 онд өвчлөгсдийн 73.2% тарилгын замаар халдвар авсныг тогтоосон. Үүнээс үндэслэн Б.Рагчаа нь вирус гепатитын өвчлөл БНМАУ-д эрс нэмэгдэж эхэлсэн онцлогийг тодруулснаараа, алаг цоог өвчлөлийн дотор ийлдэст гепатит давамгайлж байсныг нотолсноороо Монгол улсад В вирус гепатитын судалгааны эхийг тавьсан гэж академич П.Нямдаваа “Монголд элэг судлалыг үндэслэгч эрдэмтэн” илтгэлдээ 2015 онд дүгнэсэн. Өвчлөгсдийн 73.8% тарилгын болон цусаар дамждаг халдвартай холбоотойг 1969 онд тэмдэглэснээс хойш 4 жилийн дараа Австралийн эрдэмтэн В.С.Бланберг тарилгаар халддаг гепатитын В вирусийг илрүүлсэн юм¹⁶.

Профессор Б.Рагчаа элэгний өвчний талаар бичсэн бүтээлүүдээ нэгтгэж дүгнэн 1977 онд “Боткины өвчний эмнэл зүй” гэдэг нэг сэдэвт зохиол бичиж анагаахын шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын

зэргийг хамгаалжээ.⁷ “Боткины өвчний эмнэл зүй” бүтээлийг 1971 онд Улаанбаатар хотод 1800 хувь хэвлүүлэн гаргажээ. Энэхүү ном нь Орос, Англи, Франц хэл дээр товч реферат бүхий бөгөөд Монгол судлаачдын 32 ном, Оросын 172, бусад гадаад хэлний 16 ном зохиолыг ашигласан ном зүйтэй. Энэхүү бүтээл “Боткины өвчний эмнэл зүй” нэртэй боловч элэгний цочмог вирус эмгэгийн зөвхөн эмнэлзүйн судалгааг бус анатоми, физиологи, клиник болон лаборатори оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн хүрээнд дотоод, гадаадын судлаачдын 220 бүтээлээс ишлэл авч бичигдсэн нь нотолгоонд суурилсан өргөн хүрээний цогц сурах бичиг болохыг харуулж байна (Хүснэгт 3). Боткины өвчний тасагт 1955-1959 онд хэвтэж эмчлүүлсэн 524 хавсарсан эмгэггүй хүмүүс, 94 жирэмсэн, эмнэлгийн 100 ажилчид, тэмбүү өвчтэй 100, архаг архичин 61, архаг гастриттай 100, хэрэх өвчтэй 50, бусад хавсарсан өвчтэй 120, нийт 1139 өвчтөн дээр судалгааг субьектив, объектив арга, рентген, клиник-лаборатори, биохимийн аргаар Боткины өвчний шарлах үеийн клиникийн шинж тэмдгийг судалж, аливаа өвчин эмгэгийг тал бүрээс нь өвөрмөц онцлогийг тогтоосон нь үүнд тулгуурласан эрүүл мэндийн хөтөлбөрүүд хэрэгжих үндсэн судалгааны эхлэл болж өгчээ. Мөн Боткины өвчтэй хүний 7 хоног хэрэглэх үлгэрчилсэн хоолны цэсийг гаргаж, хоолны илчлэгийг тооцсон нь элэгний эмгэгийн үеийн хоол эмчилгээний суурь ойлголтыг гаргаж иржээ^{17,18}.

Хүснэгт 3. Боткины өвчний эмнэл зүй номын ерөнхий агуулга

Хэсэг	Бүлэг	Ерөнхий агуулга	Хуудас
I (Ерөнхий анги)	1	Элэгний морфологи- дүрс судлал	7-11
	2	Элэгний физиологийн үүрэг ажиллагаа	17-24
	3	Элэг цөсний өвчтөний клиник оношилгоо	26-37
	4	Элэг цөсний өвчнүүдийн ерөнхий ба хам шинжүүд	45-57
	5	Элэгний өвчний лабораторийн шинжилгээ	61-105
II (Боткины өвчний анги)	6	Шалтгаан, тархалт, патогенез, эмгэг анатоми, эмнэл зүй, онош, эмчилгээ, сэргийлэлт	106 -161
III (Халдварт гепатитийн Монгол дахь онцлог)	7	Товч түүх, тархалт, клиникийн явцын онцлог	162-169
	8	Физиологийн ба эмгэгийн өвөрмөц байдалд халдварт гепатитын явцын онцлог (жирэмсэн, хүүхэд, настан, архаг архичин, эмнэлгийн ажилчид, тэмбүү, сүрьеэ, ходоодны архаг үрэвсэл, хэрэх, бусад)	205-229
	9	Эмчилгээ, урьдчилан сэргийлэлт (дэглэм, хоол, эмийн эмчилгээ)	232-252

Элгэнд хатгалт хийж эдийн сорьц авах эмгэг гистологийн шинжилгээ нь элэгний эмгэгүүдийг ялган оношлох, өвчний явцыг болон эмчилгээний хүндрэл, үр дүнг хянах шинжилгээ юм. 1883 онд Paul Ehrlich нарийн зүүгээр элэгний цуллаг эд рүү хатгалт хийж чихрийн шижинтэй өвчтөнүүдийн элгэнд гликогены

нөөцийг тодорхойлсноор анагаах ухааны практикт анх нэвтрүүлжээ. 1958 онд Menghini “Нэг секундний элэгний хатгалтын эд сорьц” хэмээх техник болон Menghin-ий зүүг танилцуулсан ба түүнээс хойш арга технологи сайжирсаар ирсэн нь сүүлийн 50 гаруй жилд элэгний өвчний оношилгооны алтан стандарт

шинжилгээ болоод байна.¹⁹ Академич Б.Рагчаа “Элэгний биопсийн ач холбогдол, үд дүн” сэдвээр Сэлэнгэ аймгийн эмч нарын конференцэд илтгэл (1966 он) хэлэлцүүлсэн нь манай улсад энэ сэдвээр

тавигдсан анхны илтгэл байжээ. Академич Б.Рагчаа багшийн удирдлага дор олон шавь нар нь элэгний эмгэгийн судалгаа, шинжилгээ хийж эрдмийн зэрэг хамгаалжээ.²⁰ (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Академич Б.Рагчаагийн элэгний чиглэлээр удирдан хамгаалуулсан эрдэмтэн

№	Эрдэмтний нэр	Судалгааны сэдэв	Он
1	Т.Гомбосүрэн	Боткины өвчний тархалт судлал	1969
2	Б.Дагвадорж	Элэгний үрэвслийн шинж тэмдэг, оношилгоо	1984
3	П.Онхуудай	Элэгний хорт хавдар, бэтгийг сцинтиграфийн аргаар оношлох асуудалд	1991
4	Б.Цэрэндаш	Элэгний ацетилжуулах чадварыг эсийн хамгаалах үйл ажиллагаатай холбосон судалгаа	1994

Дотрын анагаах ухааны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний материаллаг бааз хөгжиж, өнөөг хүртэл хөгжиж байгаа нь Б. Рагчаагийн нөр их хөдөлмөр бүтээлтэй салшгүй холбоотой билээ.

Дүгнэлт:

1. Бямбажавын Рагчаа нь 1953 онд “Дотор өвчний онош зүйн” тэнхимийн анхны монгол эрхлэгчээр томилогдсоноос хойш 52 жил багшилж, 42 жил дотрын зөвлөхөөр ажилласан ба дотрын онош зүйн шинжлэх ухаанд чухал хувь нэмэр оруулсан нэрт эрдэмтэн байжээ.
2. Академич Б.Рагчаа нь вируст гепатитын судалгааг удирдан явуулж, “Боткины өвчний эмнэл зүй” нэг сэдэвт зохиол бичиж хэвлүүлэн АШУ-ны докторын (1977) зэрэг хамгаалсан элэгний анхны мэргэжлийн эрдэмтэн судлаач багш юм.

Ном зүй:

1. АШУИС-ийн Сувилахуйн сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургууль. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Эрүүл мэндийн салбарын түүхэн хөгжил. Улаанбаатар хот. 2022:8.
2. Шинжлэх ухааны академи. Монгол улсын шинжлэх ухааны түүх II боть. Улаанбаатар хот. 2021:16.
3. Бадамжав С. Б.Рагчаа 100 жил. Улаанбаатар хот. 2016:26.
4. Улсын төв номын сан фонд. 2005:134.
5. Туул Н, Одонтунгалаг Н. Гастроэнтерологийн төвийн түүхэн замнал. Улаанбаатар хот. 2015:6.

6. Бадамжав С. Монголд элэг судлалыг үндэслэгч эрдэмтэн. Улаанбаатар хот. 2015:44.
7. ЭМШУИС. Монголын анагаахын мэргэд V боть. Улаанбаатар хот. 2005:180-188.
8. Рагчаа Б. Туурвиж хэвлүүлсэн бүтээлүүдийн нийлбэрийн хураангуй. Улаанбаатар хот. 1978.
9. Цэрэндаш Б. Монгол улсын шинжлэх ухаан 99. Улаанбаатар хот. 2009:7-8.
10. ЭМШУИС. Монголын анагаахын мэргэд V боть. Улаанбаатар хот. 2005:86-89.
11. Алтантуул Д. Академич Б.Рагчаагийн дотор өвчний онош зүйн бүтээлийн судалгаа. Магистрын диссертацийн ажил. Улаанбаатар хот. 2016:8.
12. Рагчаа Б. Дотор өвчний хам шинж. Улаанбаатар хот 1972.
13. ЭМШУИС. Монголын анагаахын мэргэд V боть. Улаанбаатар хот. 2005:160.
14. Бадамжав С. Б.Рагчаа 100 жил. Улаанбаатар хот. 2016:106.
15. Нямдаваа П. Вакцин хэмээх ээлтэй Үхэржсин. Улаанбаатар хот. 2009.
16. Бадамжав С. Б.Рагчаа 100 жил. Улаанбаатар хот. 2016:129-137.
17. Рагчаа Б. Боткины өвчний эмнэлзүй. Улаанбаатар хот. 1969.
18. Долгион Д. Академич Бямбажавын Рагчаагийн “Элэг судлал”-ын бүтээлийн судалгаа. Магистрын диссертацийн ажил. Улаанбаатар хот. 2021.
19. Бадамжав С, Эрдэнэцогт Д, Баатархүү О. Элэгний биопсийн шинжилгээ. Улаанбаатар хот. 2019:14-15.
20. Нямдаваа П, Лхагва Л, Бурмаа Б. XX зууны Монголд Анагаах ухаан хөгжсөн түүхийн товчоон. Улаанбаатар хот. 2001:25-27.

The Contribution of Academician Byambajav Ragchaa to the Development of Internal Medicine Diagnostics and Hepatology

Dolgion D^{1,2}, Tulgaa L², Bira N¹, Badamjav S¹, Enkh-Amar A¹

¹Department of Gastroenterology, School of Biomedicine, MNUMS

²Institute of Medical Sciences, Ministry of Economy and Development,
E-mail: dolgion.ims@mnumns.edu.mn, Tel: +976-99659303

Background: Academician Ragchaa B made a profound contribution to the foundation and development of internal medicine in Mongolia. He was among the first graduates of the Faculty of Medicine at the National University of Mongolia, becoming the country's first internal medicine physician, educator, and researcher in the field of internal pathology. Ragchaa B achieved numerous pioneering roles, including being the first Mongolian head of the Department of Internal Medicine, and the first professor in this specialty. His extensive contributions helped establish and advance internal medicine and medical education in Mongolia.

Aim: The aim of this study is to analyze the scholarly works of Academician Ragchaa Byambajav to explore and disseminate his valuable contributions to the foundation and development of the science of "Internal Medicine Diagnostics" and hepatology.

Materials and Methods: This study utilized a documentary research method to analyze the contributions of the distinguished scholar, Academician Ragchaa B. The research involved a comprehensive review of his published books, textbooks, scientific articles, presentations, and archival materials. Additionally, the study examined references to Ragchaa B in books, newspapers, and collected written and oral recollections from his former students across different generations. Through systematic analysis of these sources, the study aimed to provide an in-depth understanding of his academic and professional legacy.

Results: Academician Ragchaa B, during his teaching career, graduated approximately 4,000 medical professionals and produced a total of 156 scholarly works. Drawing from his vast knowledge, skills, and experience, he became renowned for writing the textbooks "Clinical Aspects of Botkin's Disease" (1969) and "Diagnosis of Internal Diseases" (1970), earning recognition as the first scholar to author a Mongolian medical textbook.

In 1977, Professor Ragchaa B consolidated his research on liver diseases and authored the monograph "Clinical Aspects of Botkin's Disease," which led to him earning the Doctor of Medical Sciences (Sc.D.) degree.

Conclusion:

1. Academician Ragchaa Byambajav was a distinguished scholar who made significant contributions to the science of internal medicine diagnostics. He served as the first Mongolian head of the "Department of Internal Medicine Diagnostics" in 1953, teaching for over 50 years and acting as a consultant in internal medicine for more than 40 years.
2. He directed research on viral hepatitis and authored the monograph "Clinical Aspects of Botkin's Disease", which led to his achievement of a Doctor of Medical Sciences degree in 1977. This accomplishment established him as the first specialized researcher and educator in hepatology in Mongolia.

Keywords: Medical Science, Viral Hepatitis, Contribution, History, Scientific Research